



# ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/258

Эрдэнэт

## Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4./в/, 29.2 дахь заалт, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрдэнэт хотын 1,2,3,5 дугаар хороолол болон Дэнж багийн зарим орон сууцны барилгын дээврээс ус их хэмжээгээр орж иргэдийн тав тухтай амьдрах нөхцөл алдагдаж байгаа тул засварын ажилд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.


2.Дээрхи ажилд шаардагдах 147143360 /Нэг зуун дөчин долоон сая нэг зуун дөчин гурван мянга гурван зуун жаран/ төгрөгийг болзошгүй аваарийн зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлыг Хотын захирагчийн алба /н.Түмэнжаргал/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны  
05 дугаар сарын 8-ны өдрийн  
1658 дугаар захирамжийн хавсралт

**ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН БАЙРУУДЫН  
ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН АЖЛЫН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ**

№	Зардлын нэр	Зардал /төгрөг/
1	Орон сууцны 3 дугаар хорооллын 13 дугаар байрны 1 дүгээр блокын дээвэр засварын ажил	18612166
2	Орон сууцны 5 дугаар хорооллын 18 дугаар байрны 2 дугаар блокын дээвэр засварын ажил	19616511
3	Дэнж баг, Орон сууцны 2 дугаар байрны 1 дүгээр блокын дээвэр засварын ажил	19517210
4	Орон сууцны 1 дүгээр хорооллын 19 дүгээр байрны 1 дүгээр блокын дээвэр засварын ажил	17465200
5	Орон сууцны 1 дүгээр хорооллын 2 дугаар байрны 4 дүгээр блокын дээвэр засварын ажил	17708752
6	Орон сууцны 2 дугаар хорооллын 10 дугаар байрны 1 дүгээр блокын дээвэр засварын ажил	16938946
7	Орон сууцны 2 дугаар хорооллын 22 дугаар байрны 2 дугаар блокын дээвэр засварын ажил	19790957
8	Орон сууцны 3 дугаар хорооллын 7 дугаар байрны 3 дугаар блокын дээвэр засварын ажил	17493618
	Дүн	147143360